

БАТЛАВ. СУРГАЛТ, ОЮУТНЫ ХӨГЖИЛ ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР Н.ЭРДЭНЭХҮҮ



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НАМРЫН УЛИРЛЫН “ЭРДМИЙН БАЯР”
ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-т Шинжлэх ухаан, технологийн их сургууль нь Монголын үндэсний дээд боловсролтой мэргэжилтэн эх орондоо сургаж бэлтгэх ажлыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1959 оны тогтоолоор эхлүүлж 6 аравны түүхийг бүтээж яваа Монголын ууган их сургуулийн нэг билээ.

2025-2026 оны хичээлийн жилд бакалаврын **95**, магистрын **57** дах удаагийн “Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагааг тэмдэглэх гэж байна.

Арга хэмжээний зорилго:

ШУТИС-ийн 2025-2026 оны хичээлийн жилийн намрын улирлын “Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагааг ёслол төгөлдөр зохион байгуулахад оршино.

Хамрах хүрээ:

ШУТИС-ийн эрдэмтэн багш, ажилтан, төгсөгчид, гэр бүл оролцоно.

Хэзээ: 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр 11:00-13:30 цагт

Хаана: “Соёлын төв өргөө”-нд болно

Төгсөгчдийн тоо:

- Доктор: 2
- Магистр: 171
- Бакалавр: 599
- Политехник коллеж: 60

Нийт: 832

Арга хэмжээний зохион байгуулалт:

- “Эрдмийн баяр”-ын үйл ажиллагаанд Улаанбаатар хотод нийт 830 гаруй төгсөгч хамрагдана. Дархан, Эрдэнэтийн сургууль орон нутагтаа гардуулна.
- Төгсөлтийн баярын үйл ажиллагаанд нийт төгсөгчид, ШУТИС-ийн удирдлагууд, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд, эрдэмтэн багш нар оролцоно. Үүнд:

№	Үйл ажиллагаа	Хамрагдах төгсөгчийн тоо	Огноо	Цаг	Оролцох удирдлагууд
1	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	90	2026.01.21	11:00-13:30	Т.Намнан Н.Эрдэнэхүү Д.Цолмонбаатар В.Өлзийбаяр Р.Бадмаанямбуу Л.Баяр-Эрдэнэ Г.Баттүвшин Н.Ганзориг Н.Пүрэвдорж К.Хавалболот Бя.Бат-Эрдэнэ Б.Нарантуяа Я.Төгөлдөр Б.Тунгалагтамир Ц.Энхбаатар Д.Ганбат Б.Сүхбат
	Менежментийн сургууль	30			
	Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайны сургууль	73			
	Механик инженер, тээврийн сургууль	52			
	Геологи уул, уурхайн сургууль	42			
	Эрчим хүчний инженерчлэлийн сургууль	75			
	Барилга архитектурын сургууль	98			
	Нийгэм, хүмүүнлэгийн сургууль	12			
	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	21			
	Гадаад хэлний сургууль	14			
	Политехник коллеж	60			
	Нийт	567			
2	ДаТС	74	2026.01.21	11:00-13:30	Орон нутагт тусдаа гардуулна.
3	ЭЦДС	18			

Анхааруулга:

- “Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагаанд оролцож буй нийт төгсөгчид 30 минутын өмнө хүрэлцэн ирж суудлаа эзэлсэн байна.
- Бүх түвшний төгсөгчид эрдмийн баярын ёслолын өмсгөлөө бүрэн өмссөж ромбо зүүсэн байна.

НЭГ: “ЭРДМИЙН БАЯР” ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН

АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

“Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагааны заал, тайзыг урьдчилан бэлтгэж ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулна.

2026.01.21-ний өдрийн 11:00-13:30 цагийн арга хэмжээний хөтөлбөр

/МХТС, МС, ХХҮДС, МИТС, ЭХИС, ГУУС, БАС, НХС, ХШУС, ГХС, НБТ, ПК /

10:30-11:00 Соёлын төв өргөөний хурлын танхимд төгсөгчид суудлаа эзлэх

11:00-11:03 Нээлт Хөтлөгч

11:03-11:05 ШУТИС-ийн удирдлагууд, хүндэт зочдыг танилцуулна.

11:05-11:15 ШУТИС-ийн Ректор доктор, профессор Т.Намнан мэндчилгээ дэвшүүлж үг хэлнэ.

11:15-11:25 Боловсролын яамны дэд сайд, ШУТИС-ийн удирдах зөвлөлийн дарга, Д.Гантулга мэндчилгээ дэвшүүлж үг хэлнэ.

11:25-11:28 Төрийн дуулал эгшиглэнэ.

11:28-11:35 Төгсөгчдөд диплом олгох Ректорын тушаалыг Сургалтын бодлого, зохицуулалтын албаны дарга доктор, М.Эрдэнэтуяа уншиж танилцуулна.

11:35-12:35 Диплом гардуулах үйл ажиллагаа: Диплом, гардуулах зочдыг урих (Төгсөгчдийн нэрсийг дуудаж, дипломыг хүндэтгэлтэйгээр гардуулна)

- Докторын зэрэгтэй төгсөгчид
- Магистрын зэрэгтэй төгсөгчид
- Бакалаврын зэрэгтэй төгсөгчид
- Политехник коллежийн төгсөгчид

12:35-12:45 Шилдэг, тэргүүний төгсөгчдөд шагнал гардуулах ажиллагаа

12:45-12:50 Морин хуурын мэндчилгээ

12:50-12:55 Профессорын мэндчилгээ. /Академич, Шинжлэх ухааны гавъяат Х.Энхжаргал/

12:55-13:00 Магистрын зэрэг хүртсэн төгсөгч үг хэлнэ. /ЭХИС-Л.Номин/

13:00-13:05 ШУТИС-ийн бакалаврын шилдэг төгсөгч үг хэлнэ. /МХТС-Б.Пүрэвжаргал/

13:05-13:10 ШУТИС бидний бахархал дуу

13:10-13:15 Төгсөгчдийн тангараг өргөх ёслол

13:15-13:20 Малгай шидэлтийн баяр

13:20-13:30 Ёслолын ажиллагааны хаалт

ХОЁР. “ЭРДМИЙН БАЯР” ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албуудад өгөх зөвлөмж

- ✓ Бүрэлдэхүүн сургуулиудын сургалт, чанарын алба, төгсөлтийн нарийн бичгийн дарга, оюутны үйлчилгээний алба төгсөлтийн ёслолын ажиллагааг хамтран зохион байгуулна.
- ✓ Төгсөлтийн ёслолын ажиллагаанд дараах дарааллын дагуу нэрсийг дуудаж дипломыг гардуулна. /Доктор, магистрын шилдэг, магистр, бакалаврын шилдэг, тэргүүний, бакалавр/
- ✓ Бүрэлдэхүүн сургууль тус бүр диплом гардан авах төгсөгчдийн нэрсийг төгсөлтийн арга хэмжээг хөтлөх хөтлөгчид өгч нэрсийг зарлуулан дипломыг гардуулна.
- ✓ Төгсөлтийн хуваарь, дуудах нэрсийн дарааллын дагуу төгсөгчдийн бүх дипломыг бэлтгэн бэлэн болгосон байна.
- ✓ Төгсөгчдөд тууз, энгэрийн тэмдэг /ромбо/-г урьдчилан тарааж зүүлгэсэн байна.
- ✓ Төгсөгчдийн суудал хуваарилалтыг нарийвчилсан тоо тодорхой болсны дараа СА-нд хүргүүлж, хариуцсан салбар, тэнхимийн багш нарт хүлээлгэн өгч төгсөгчдөд мэдээлэл хүргүүлсэн байна.
- ✓ Төгсөлтийн нарийн бичгийн даргыг зохион байгуулалтад оролцуулан төгсөгч оюутнуудыг танхимд оруулах, арга хэмжээ дуустал заалнаас гаргахгүй эмх цэгцтэй байлгах, төгсөгчдөд тайлбар зөвлөмж хүргэх.
- ✓ Хоцорсон, оролцоогүй оюутны дипломыг буцаан авч ёслолын бус цагаар гардуулна.
- ✓ Тусдаа байртай сургуулиуд хичээлийн I дугаар байрны 102, 107, 112 тоот ангиудыг ашиглаж болно.

Бүрэлдэхүүн сургуулийн төгсөлтийн нарийн бичгийн дарга нарт өгөх зөвлөмж:

- ✓ Тэнхимийн оюутнуудыг ёслолын ажиллагааны хуваарийн дагуу цагт нь бүртгэж оруулна. Арга хэмжээ эхэлсэн цагаас дуусах хүртэл танхимд суулгах.

Төгсөгчдөд өгөх зөвлөмж:

- ✓ Төгсөлтийн ёслолын үйл ажиллагаа 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн өглөөний 11:00 цагаас хуваарийн дагуу зохион байгуулагдана.
- ✓ Төгсөлтийн ёслолын ажиллагаанд нийт төгсөгчид хуваарийн дагуу диплом гардаж авна.
- ✓ Төгсөлтийн ёслолын арга хэмжээг 2 цаг 30 минутын хугацаанд зохион байгуулагдана. /Хуваарьт хөтөлбөрийн дагуу/
- ✓ Төгсөгчид хувцас солих, ёслолын арга хэмжээнд оролцох бэлтгэлээ хангах, бусад эд зүйлээ соёлын төв өргөөний өлгүүрт үлдээх.
- ✓ Төгсөгчид хуваарьт цагаас 1 цагийн өмнө ирж, арга хэмжээ эхлэхээс 30 минутын өмнө суудлаа эзэлсэн байна.
- ✓ Нийт төгсөгчид СТӨ-нд төгсөлтийн нарийн бичгийн даргаас хуваарилсан өөрийн дугаарлалт бүхий суудалд сууж, эгнээ тус бүрээр дипломоо гардан авна.
- ✓ Тууз, энгэрийн тэмдэг /ромбо/-г урьдчилан зүүсэн байна.
- ✓ Диплом гардуулах үеийн дурсгалын зургийг [Drive.google.com](https://drive.google.com) холбоосоор нээлттэй байршуулна.

- ✓ Төгсөгчид арга хэмжээ дууссаны дараа тухайлан засаж бэлтгэсэн газруудад дурсгалын зургууд татуулна.

Эцэг, эхчүүдэд өгөх зөвлөмж:

- ✓ Төгсөгчдийн ар гэрийнхэн ШУТИС-ийн цахим хуудсаар шууд дамжуулалтыг хүлээн авч үзэх боломжтой.
- ✓ Эцэг, эхчүүдийг арга хэмжээ зохион байгуулагдаж буй танхимд оруулахгүй болохыг анхаарна уу.
- ✓ Төгсөгчдийн ар гэрийнхэн СТӨ-ний үүдний хэсэгт бэлтгэсэн зориулалтын талбайд дурсгалын зураг татуулж болно.

Хувцас солих анги хуваарилалт

№	Сургуулийн нэр	Хичээлийн байр	Өрөөний дугаар, анги	Хариуцах эзэн
1	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	1-р байр	107 тоот	ХХҮДС, ОҮА
2	Менежментийн сургууль	1- байр	102 тоот	ХХҮДС, ОҮА
3	Механик инженер, тээврийн сургууль	1-р байр	112 тоот	ХХҮДС, ОҮА
4	Хүнс хөнгөн үйлдвэрлэл дизайны сургууль	Төгсөгчид сургалтын албанаас тодруулна.		
5	Геологи уул, уурхайн сургууль			
6	Эрчим хүчний инженерчлэлийн сургууль			
7	Барилга архитектурын сургууль			
8	Нийгэм, хүмүүнлэгийн сургууль			
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль			
10	Гадаад хэлний сургууль			